

НЭРТ ГҮҮШ Б.БАНЗРАГЧИЙГ ДУРСАН БИЧИХЭД...

Б.Соёлсүрэн¹⁴⁶

Товч утга: Монголын хөгжлийн нэгээхэн үеийн шилдэг сэхээтний нэг, олноо “Улаан эрдэмтэн” хэмээн алдаршсан эрхэм хүн Б.Банзрагч гуайн амьдрал, уран бүтээлээс судлан энэхүү өгүүллээ бичсэн.

Монголын бичгийн их хүмүүсийн нэг адил багаасаа эрдэм номд шамдан сурч, бичээчээр ажиллан, улмаар ЗХУ-д суралцан орос хэлийг чадамгай сурчээ. Амьдралынхаа олон жилийг бичиг цаастай холбон өнгөрүүлсэн орчуулагч, сэтгүүлч Б.Банзрагч орос хэлнээс нийгэм, улс төрийн холбогдолтой олон зохиол бүтээл орчуулан монголын түүхэн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан хүн юм.

Түлхүүр үг: “Улаан эрдэмтэн”, “Маркс, Лениний номлох зүйлийг орчуулах коллеги”, Улсын нэр томъёоны комисс, Судар бичгийн хүрээлэн, “Үнэн” сонины эрхлэгч, “Шинэ толь” сэтгүүл

1. Сургууль эрдмийн мөр хөөсөн нь

Б.Банзрагч гуай энэ хорвоод ер шахам жил амьдарч адармаатай ээдрээтэй, бас ч сонин цаг үеийг туулан өнгөрүүлжээ. 1907 онд Түшээт хан аймгийн Дайчин бэйсийн хошуу одоогийн Дундговь аймгийн Гурван сайхан сумын нутагт сумын занги Бархасын гэрт төрж өссөн ч бага насандаа гэрээр монгол бичиг сурч, хошууны бичээчээс бичгийн их хүний амьдралын гараагаа эхэлсэн ажээ. 1925 онд Улаанбаатар хотод намын түр сургуульд оржээ. Тэндээ хэдэн сар суралцсаны дараа намын төв хорооны томилолтоор ЗХУ-ын Москва хотод Дорно дахины сургууль буюу КУТВ сургуульд таван жил суралцан, 1930 онд амжилттай төгсгөн Улаанбаатар хотноо буцан иржээ.

Түүнтэй хамт орон орны улс төрийн зүтгэлтнүүд суралцаж байснаас Болгар улсаас олон жил төрийн тэргүүнээр ажилласан Т.Живков хамт сурч байсан ба тэрээр хожим Т.Живковын түүхэн ойн ёслолын үйл ажиллагаанд оролцож байсан.

Тэр эрдэм ном, орос хэлийг нэвтэрхий сайн сурсан тул монголдоо ирээд Большевик намын (Бо намын түүх) түүхийг намын сургуульд дагнан заах болж, улмаар Улаан эрдэмтэн Банзрагч хэмээх нэрийг олон түмнээс авсан байна.

2. Орчуулагч Б.Банзрагч

Түүний 85 насны сүүдэр зэрэгцсэн ойг тохиолдуулан Монголын орчуулагчдын эвлэлээс түүнд баяр хүргэсэн бичигт: “Та Монгол улсын Шинжлэх ухааны хүрээлэн, Намын түүхийн институт, “Үнэн” сонин зэрэг

¹⁴⁶ ШУТИС-ийн ГХИ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, дэд проф. доктор /Ph.D/

газарт 50 гаруй жил цуцалтгүй ажиллахдаа олон чухал өгүүлэл, нийтлэл бичиж, нийгэм-улс төрийн ном товхимол анхлан хөрвүүлэгчдийн эгнээнд явж, уран зохиол ... орчуулалцан туршлага, зүтгэлээрээ залуу үед үлгэр дуурайл болсоор ирлээ” гэж бичсэн байдаг.

Түүний орчуулгын нэр хөдөлмөр 1930 оны намар Намын Төв Хорооны ухуулан боловсруулах хэлтсийн дэргэд Маркс, Лениний зохиолыг орчуулах коллеги (Тэр үеийн нэрээр “Маркс, Лениний номлох зүйлийг орчуулах коллеги”) байгуулж, түүний бүрэлдэхүүнд Б.Банзрагч, Б.Дугаржав, Б.Ишдорж, Л.Цэндсүрэн, Ц.Нацов, З.Шижээ, Б.Элдэв-Очир, Д.Цэвэгжав, С.Магсар, Дашнямаев нар орж ажиллан, нэлээд зохиолыг хамтран орчуулсны дотор К.Марксын “Фейрбахын сэдвүүд”, В.И.Лениний “Марксизмын гурван уг, гурван үндсэн зүйл” (Шинэ орчуулгаар “Марксизмын гурван эх сурвалж, бүрэлдэхүүний гурван хэсэг”), “Зөвлөлт засгийн ээлжит зорилт”, “Нийгэм журам ба шашин”, “Коммунист Интернационалын II их хуралд үндэстний ба колонийн асуудал эрхэлсэн комиссын тавьсан илтгэл” гэх зэрэг зохиолыг монголчлоход оролцсоноор эхэлсэн ажээ. Мөн “Бүх Холбоотын эв хамт (большевикуудын) намын товч түүх”-ийг Ш.Лувсанвандан, Ж.Дүгэрсүрэн нартай хамтран орчуулжээ. 1950-1960-аад онд Лениний 35 боть зохиолыг бүрэн орчуулан гаргахад өвгөн эрдэмтэн идэвхтэй зүтгэж, сүүлчийн 7 ботийг орчуулах, хянан тохиолдуулахад оролцжээ. Үүнээс гадна, дотоод гадаадын намуудын их болон бүгд хурлын илтгэл, дээд газруудын албан ёсны баримт бичгийг хөрвүүлэх ажилд биечлэн оролцож байжээ.

Б.Банзрагч гуай Улсын нэр томъёоны комиссын ажилд оролцож нэр томъёо тогтооход зохих хувь нэмрээ оруулж байжээ. Жишээ нь, 1940-50-иад онд “Үнэн” сонинд ажиллаж байхдаа С.Бадраа, Д.Дашдорж нартай хамт ТАСС-ын мэдээ, бусад материалыг шууд телетайпаас авч дор нь орчуулан сонинд нийтлэх, радиогаар нэвтрүүлэх явцад зарим нэр томъёог монголоор зохиож хэвшүүлсэн ажээ. Тухайлбал, *проект* гэдгийг *төсөл*, *рецензия* гэдгийг *шүүмж* гэж анх нэрлэж бичсэнийг нийтээр даган мөрдөх болжээ. Банзрагч гуай бас уран зохиолын бүтээлээс, тухайлбал В.Г.Яны “Бат хаан” хэмээх зохиолыг Ш.Цэвэгтэй элбэж, орчуулсан байна.

Б.Банзрагч гуай эх хэл, соёлоо эрхэмлэн дээдлэх талаар их анхаарч, ялангуяа 1990-ээд оноос монгол хэлэнд харь үг хэллэг олноор нэвтэрч, хэлний засаг алдагдаж байгаад сэтгэл нь эмзэглэж байлаа. 1980-аад оны сүүлч 90-ээд оны эхээр сонинд гарсан миний зарим өгүүллийг уншаад бодол сэтгэгдлээ бичиж өгснийг дор уг эхээр нь сийрүүлэв: “Би уншиж их таашаалаа. Хэлээ бүрмөсөн эвдрэхээс хамгаалах талаар санаа тавих цаг болжээ. Ингэхэд:

1. Хэл зохиолын хүрээлэн энэ талаар санаа зовж байна уу?
2. УНТ (Улсын нэр томъёоны комисс) унтаад л байна уу. Ер нь тэр комисс бий юу?
3. Хэлний эрдэмтэн, мэргэжилтнүүд маань юу хийж байна вэ? Энэ бүгдийг сайн шүүмжилж унтсан нойрноос нь сэрээхсэн” хэмээж байжээ.

Б.Банзрагчийн орчуулгын хэл найруулга яруу төгөлдөр, цаад утга

чанарыг гүн ухаарч оновчтой буулгасан, бичсэн өгүүллийн агуулга хэлбэр нь уялдаа холбоо сайтай, хүний сэтгэлд хоногшин үлдэхүйц ажээ. Тэрээр хуучин, шинэ үсгээр маш сайхан гаргацтай, зөв бичдэг байсан. 1930-аад онд Ж.Цэвээн, Б.Ишдорж, Б.Ринчен нартай ойр ажиллаж, орчуулах, бичих урлагт суралцсан нь их нөлөөлсөн бизээ.

Түүхч, орчуулагч, сэтгүүлч энэ эрхэм хүний үйл бүтээл олон талтай, өргөн хүрээтэй болохоор тэр болгоныг энд дурдах боломжгүй.

Тэр үеийн шилдэг сэхээтэн залуу боловсон хүчний хувьд МАХН-ын Төв хорооны үзэл суртлын хэлтсийн эрхлэгч, Дотоодыг хамгаалах газар хэлтсийн дарга, Улаанбаатар хотын МАХН-ын хорооны дарга зэрэг ажил хийж байгаад сайн дураараа эрдмийн ажил хийхээр шийдэж, Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн даргын ажил хийж, улсад шинжлэх ухааны танин мэдэхүй, үзэл суртал дэлгэрүүлж, ард түмнийг гэгээрүүлэх, дэлхий нийтийн шинжлэх ухааны ололттой танилцуулах зэрэг ажил хийж байжээ.

Судар бичгийн хүрээлэнд байхдаа тэр үеийн нэр цуутай хүмүүсийг уриалан Гандан хийд, Амарбаясгалантын хийд зэрэг хамгийн том, сайхан хийдүүдийг хамгаалах хүсэлт гарган, түүх соёлын дурсгалыг хамгаалах нэрийн дор эвдэж сүйтгэлгүй үлдээх шийдвэр гаргуулж, хэрэгжүүлсэн нь хардлага сэрдлэг гаарч, хэнийг ч өчүүхэн шалтгаар хөнөөж байсан ширүүн үед иргэний зориг гарган, хойч үедээ түүх соёлын үнэт өвийг үлдээсэн гавьяа билээ.

Тэр цаг үеийн улс төр, үзэл суртлын хүнд бэрх байдал ихэсч, улс төрийн хэлмэгдүүлэлт гаарч байсан нь түүнийг ч бас тойроогүй. 1941 оны намар зусланд гарч байхад өлгийтэй охин, нялх биетэй эхнэр хоёрыг нь уйлуулан гэрээс нь баривчилж, Судар бичгийн хүрээлэнгийн ажлыг Банзрагч тэргүүнтэй японы эсэргүү байгууллагын тагнуулууд нураах үүрэг даалгавартай ажиллаж байсан гэсэн ял тулган гарын үсэг зурахыг шаардаж, эрүү шүүлт хийж байсан гэдэг.

Багаас сурсан ажил, мэдлэг ухаан нь түүнийг бас л аварсан. Түүнийг шоронд байхад ХААЯамны орос мэргэжилтэн яамны ажил сайжруулахад оросоос их бичиг баримт орчуулах чухал шаардлага байхад хэлний сайн орчуулагч шоронд байна түүнийг ашиглая гэсэн санал гаргаж, орчуулах материалууд өгч байжээ. Түүнтэй хамт Наваан-Юндэн нарын чадвартай хүмүүс тусгай гэрт сууж хоригдож байжээ. Тэрээр энэ үедээ В.Яны зохиол “Бат хаан” гэдэг номыг орчуулсан гэдэг.

Тэр үед “Үнэн” сониныг орос хэл дээр хэвлэн гаргах гээд чадахгүй байжээ. Х.Чойбалсан энэ талаар зөвлөж байхад хэн нэг нь энэ ажлыг чадах хоёр хүн байна. Даанч хоёулаа шоронд байна, хэн бэ гэхэд Б.Ренчин, Улаан эрдэмтэн Банзрагч нар байна гэж хэлснээр Б.Ренчин гуайг шоронгоос суллаж байсан гэж 1990-ээд оны сонин дээр гарч байв.

Хилс хэрэгт гүтгэгдэж 25 жил сонсоод, таван жил хагас сууж байх үед 1946-47 оны эхээр Ардын их хурлын зарлиг гарч суллагдсан ба 1957 онд цаатгагдсан. Тэрээр хэлмэгдлээс ангижирч гарснаас хойш ажил амьдралаа үргэлжлүүлж “Үнэн” сонины эрхлэгч, “Утга зохиол” сэтгүүлийн эрхлэгч,

Намын түүхийн институт зэрэг газруудаар ажиллан орчуулагч, сэтгүүлчийн ажлыг хийж явсан. Лениний ботийг Монголд анх орчуулж Ю.Цэдэнбал даргаас мөнгөн шагнал авч явсан гэдэг.

3. Сэтгүүлч Б.Банзрагч

Б.Банзрагч хар бага наснаасаа монгол хэл бичиг сайн сурч, нам эвлэлийн үүрийн ханын сонины эрхлэгчээс эхлэн намын төв хэвлэл “Үнэн” сонин “Нийгэм журмын зам” (Намын амьдрал), мөн “Шинэ толь” (Шинжлэх ухаан амьдрал) сэтгүүлийн эрхлэгч “Энх тайван, социализмын асуудал”, “Октябрийн туяа” сэтгүүлд 30-аад оноос 70-аад он хүртэл ажиллаж ирсэн манай ахмад туршлагатай сэтгүүлч бөгөөд Б.Банзрагчийн олон жилийн үр бүтээлч хөдөлмөрийг нам, засаг үнэлж “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одон, “Хөдөлмөрийн хүндэт медаль” зэрэг одон медалиар шагнажээ. Сэтгүүлзүйн асуудлаар түүний бүтээсэн хөдөлмөрийг үнэлж, Монголын сэтгүүлчдийн холбоо анхныхаа нэрэмжит шагналыг түүнд олгожээ.

Б.Банзрагч гучин хэдэн онд “Шинэ толь” хэмээх анхны сэтгүүлийг санаачлан түүндээ гавьяат уран зохиолч С.Буяннэмэхийн “Гайхамшигт учрал”, Д.Нацагдоржийн “Миний нутаг”, Ц.Дамдинсүрэнгийн “Буурал ээж минь” хэмээх алдарт бүтээлүүдийг хэвлэн нийтэлж, олны хүртээл болгож байжээ.

Б.Банзрагч гуайтай “Үнэн” сонинд олон жил хамт ажиллаж байсан ахмад сэтгүүлчид түүний ажилч хичээнгүй, даруу сайхан зан чанар, шулуун шударга, ариун цагаан сэтгэл, социалист ёс суртахууны хэм хэмжээ, ажлын сахилга хариуцлагыг эрхэмлэдэг, хамт олонтой нийлэмжтэй эвсэг, намч, зарчимч байр суурийг нь хэлдэг. Сонинд ажиллах хугацаандаа улс орноо хөгжүүлэх, орон нутгийн удирдлагыг бэхжүүлэх, ажлын сайн арга барил, шинэ санааг дэмжин дэлгэрүүлэх, дутагдал доголдлыг засан арилгах талаар олон нийтлэл бичсэн. Тэрээр “Үнэн” сонины газрын утга зохиолын нарийн бичгийн даргаар олон жил ажиллаж сонин хэвлэлд нийтлэх материалыг утга зохиолын талаар хянан найруулах, засах залруулах хялбар бус ажлыг арав гаруй жил хийж байлаа.

МАХН-ын Түүхийн Хүрээлэнд орчуулгын тасгийн эрхлэгчээр ажиллаж байгаад нэрт гүүш маань 1966 онд өндөр насныхаа тэтгэвэрт гарсан ч тэр үед орос хэлнээс мэргэжлийн орчуулга хийх шаардлага их байснаас орчуулгын ажил зав зайгүй хийдэг байжээ. Улмаар 1970-аад оноос ЗХУ-ын Улаан-Үд хотод очиж монгол хэлээр хэвлэгдэн гардаг “Октябрийн туяа” сэтгүүлийн орчуулагч-редактораар гурван жил ажиллаж байжээ.

Энэхүү богино өгүүллэгийг бичихэд Б.Банзрагч гуайн амьдрал, уран бүтээлийн тухай түүхийн баримт материалаар тусалсан түүний охин Б.Цэцэгмаад талархал илэрхийлье.

Дүгнэлт

Б.Банзрагч гуай 1921 оны хувьсгалаас хойш төрсөн манай үндэсний сэхээтнүүдийн нэг юм. Тэрээр орос хэлнээс нийгэм улс төр, уран зохиолын орчуулга хийж байжээ. Орчуулгын бүтээлүүд дээр тухайн үеийнхээ

шаардлагаар баг хамт олноороо хамтран ажиллаж байжээ. Б.Банзрагч нь манай улсын гол сонин, сэтгүүлд ажиллаж Монголын сэтгүүлзүйд өөрийн хувь нэмрээ оруулсан чадварлаг сэтгүүлч юм.

Ашигласан хэвлэл:

1. “Ахмад сэтгүүлчдийн өв нь үлдэг”1989 Ред. Д.Цэрэндавга
2. http://mongoliantranslation.blogspot.com/2010/05/blog-post_14.html
Эрдэммэдлэгүнэдорно